*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ҮНДЭСНИЙ БОЛОН ДЭД ХӨТӨЛБӨР, ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН И.ОТГОНЦЭНДИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт-ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр нөлөө, үр дагаврыг үнэлэн, мэдээлж тайлагнах” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан шийдвэрийн хэрэгжилт, үр дүнг холбогдох шатны хурлаар хэлэлцүүлэх | -Хяналтад авагдсан шийдвэрийн заалтын тоогоор<br>-Холбогдох шатны хурлаар хэлэлцүүлсэн байдал | 2023 оны жилийн эцсийн байдлаар 103 шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнасан. | 100.0 хувь | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд сумдын Засаг даргын Тамгийн газрын хэлтсүүдээс хүлээн авч нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллалаа. Энэ онд нийт 87 шийдвэрийн 142 заалт тайлагнасан. | 10-12 сард | 70.0 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 1.2.Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд байршуулж, тайлагнах | -Тайлагнасан хөтөлбөрийн тоо | 10 хөтөлбөр 100.0 хувь | 7 хөтөлбөр 100.0 хувь | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр 2017-2021 онд батлагдсан нийт 7 хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, 4 дүгээр сард Засаг даргын зөвлөлийн хурлаар, 5 дугаар сард иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн хурал, хороодын хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 27 дугаар хуралдаанд тус тус танилцуулж ажиллалаа. Хөтөлбөрүүдийн дундаж үнэлгээг тодорхой үр дүнд хүрсэн буюу 82.2 хувийн үнэлгээтэй үнэллээ. | 4-5 сар | 100.0 хувь |
| 3. | Арга хэмжээ 1.3. Аймгийн Засаг даргын 2024 оны эхний хасаг жилийн захирамжид хяналт-шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтанг мэдээллээр хангах | -Хяналт-шинжилгээ хийсэн шийдвэрийн тоо<br>-Хяналт-шинжилгээний мөрөөр өгсөн чиглэл, зөвлөмж | 0.0 хувь | 100.0 хувь | Аймгийн Засаг даргын 2024 оны эхний хагас жилийн А/01-А/517 дугаартай захирамжид хяналт-шинжилгээ хийж ажилласан. Хяналт-шинжилгээний зөвлөмжийг хэлтсүүдэд хүргүүлж, гарсан зөрчлийг арилгуулах талаар чиглэл хүргүүллээ. | 9-12 сар | 100.0 хувь |
| 4. | Арга хэмжээ 1.4.Албан тушаалын чиг үүрэгт хамааралтай асуудлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн бүртгэл хяналтыг хийж, мэдээллийн сан үүсгэх | -Мэдээлэл бүртгэлийн сангийн үйл ажиллагаа | 0.0 хувь | 100.0 хувь | Хууль тогтоомж, Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газар, Хяналт хэрэгжүүлэх газрын шийдвэрүүд, аймгийн Засаг даргын шийдвэрүүд, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хурлын тогтоол, | 3-5 сард | 100.0 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамж, Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг зэрэг шийдвэрүүдийг товъёгжуулж, мэдээллийн сан үүсгэн, цэгцэлсэн. | | |
| 5. | Арга хэмжээ 1.5.Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар удирдлага болон хэлтэс, агентлагын ажилтнууд, хэрэглэгчдийг мэдээллээр хангах | -Зөвлөмжийн тоо, зөвлөн туслах үйл ажиллагааны тоо | 0.0 хувь | 100.0 хувь | Харьяа агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад цаг үеийн ажил, тогтоол шийдвэрийн тайлагналт, тайлан мэдээний гаргалт, чанарт анхаарах зэрэг зөвлөгөө, мэдээллийг тогтмол хүргэж ажилласан. | 1-12 сар | 100.0 хувь |
| **Зорилт 2. "Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэдээлэх, тайлагнах, арга зүйн зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг сайжруулах" зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1.Нутгийн захиргааны байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээний программ нэвтрүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах | -Хамтарч ажилласан байгууллагын тоо<br>-Үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал | 0.0 хувь | 100.0 хувь | Аймгийн хэмжээнд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хянах, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үнэлгээ, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнг мэдээлэх, тайлагнах мэдээллийн цахим санг шинээр нэвтрүүлсэн. Тус ажлын хүрээнд аймгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга | 4-6 сар | 100.0 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээний зардлаас нийт 5.0 сая төгрөг зарцуулсан. Цахим мэдээллийн сангийн үйл ажиллагааг хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн бүртгэл, хяналт, зохион байгуулалт, тайлагналтын хүрээнд бүх сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын түвшинд хэрэгжүүлж эхлээд байна. | | |
| 2. | Арга хэмжээ 2.2.Сумдын ЗДТГазар болон аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын үйл ажиллагаанд явцын хяналт-шинжилгээ хийх, арга зүйн зөвлөмжөөр хангах | -Явцын хяналт-шинжилгээ хийгдсэн сумын тоо<br>-Явцын хяналт-шинжилгээ хийсэн байгууллагын тоо | 5 сум , 3 агентлаг | 4 сум, 3 агентлаг | Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад цаг үеийн ажил, тогтоол шийдвэрийн тайлагналт, тайлан мэдээний гаргалт, чанарт анхаарах зэрэг зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэж ажилласан. | 10, 11 сар | 30.0 хувь |
| 3. | Арга хэмжээ 2.3.Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын мөрөөр гүйцэтгэл сайжруулах үүрэг чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | -Агентлаг, сумдад зөвлөмж өгч ажилласан эсэх<br>-Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байдал. | 23 агентлаг, 19 сумдын ЗДТГ-т зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | 100.0 хувь | Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 1 дүгээр улиралд ажлын хэсгүүд сум, агентлагийн 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн 24 агентлаг, 19 сумдад гүйцэтгэл сайжруулах үүрэг чиглэл өгч, зөвлөмж хүргэсэн. | 1-2 сар | 100.0 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Арга хэмжээ 2.4.Нутгийн захиргааны байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | -ХШҮ-нд хамрагдсан сумдын тоо,<br><br>-ХШҮ-нд хамрагдсан байгууллагын тоо | 2023 оны үйл ажиллагааны ХШҮ-ний дүнгээр 5 сум 3 агентлаг шалгарсан. | 100.0 хувь | Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 1 дүгээр улиралд ажлын хэсгүүд 19 сум, 24 агентлагийн 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүн, үр нөлөөг үнэлэн журмын дагуу 3 агентлаг, 5 сум шалгаруулж, тус бүр зөвлөмж хүргэж ажилласан. | 1-2 сар | 100.0 хувь |
| **Зорилт 3. “Хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхыг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудыг чадавхжуулах, сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах | -Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоогоор | 2023 оны жилийн эцсийн байдлаар 8 удаагийн сургалтад нийт 170 орчим албан хаагчдыг хамруулсан. | 100.0 хувь | Харьяа агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад цаг үеийн ажил, тогтоол шийдвэрийн тайлагналт, тайлан мэдээний гаргалт, чанарт анхаарах зэрэг зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэж ажилласан. | 1-6 сар | 70.0 хувь |
| 2. | Арга хэмжээ 3.2. Улсын төсөвт байгууллагууд (төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд)-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, арга зүйн зөвлөмжөөр хангах | -Хяналт-шинжилгээ хийж ажилласан байгууллагын тоогоор | 0.0 хувь | 100.0 хувь | Улсын төсөвт байгууллагууд (төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд)-ын албан хаагчдад цаг үеийн ажил, тогтоол шийдвэрийн тайлагналт, тайлан мэдээний гаргалт, чанарт анхаарах зэрэг зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэж ажилласан. | 03-12 сард | 30.0 хувь |
| 3. | Арга хэмжээ 3.3. Хэлтсийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, аймгийн цахим сайтуудад байршуулах, сурталчлах | -Байршуулсан мэдээллийн тоо | Uvurkhangai. gov.mn вэб сайтад 4 мэдээлэл байршуулсан. | 3-аас доошгүй мэдээлэл<br><br>100.0 хувь | Хэлтсийн 2024 оны төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн хяналтад авсан бүртгэл, 2023 оны тогтоол шийдвэрийн биелэлт зэргийг Uvurkhangai.gov.mn вэб сайтад байршуулсан. | 1-12 сар | 100.0 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Мэдээлэл авсан иргэдийн тоо | | | | | |
| **Зорилт 4: “Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичигт тусгагдсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1. Төрийн албаны тухай хууль, ёс зүй, сахилга хариуцлагатай холбогдох дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах | - Төрийн албан хаагчын ёс зүйн зөрчилгүй ажилласан байдал<br>- Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоогоор | Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, холбогдох мэдээ тайланг хугацаанд гаргаж, биелэлтийг тооцон ажилласан.<br>100.0 хувь | 100.0 хувь | Төрийн албаны тухай хууль болон албан тушаалын тодорхойлолтын дагуу хүлээсэн үүргээ холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд гүйцэтгэж, ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой зөрчил гаргаагүй болно. Мөн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь гүйцэтгэж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. | 1-12 сар | 100.0 хувь |
| 2. | Арга хэмжээ 4.2. Хэлтсийн чиг үүргийн хүрээнд тайлагнах хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, тайлагнах | Хэрэгжилт, үр дүнгээр | - | Тайлан, мэдээг цаг хугацаанд нь тайлагнаж ажилласан байна.<br>100.0 хувь | Энэ онд хаагдаж буй 7 хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг ирүүлэх тухай албан тоот ирсэний дагуу Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр 2017-2021 онд батлагдсан нийт 7 хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, тайланг хүргүүлэн 5 дугаар сард иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн хурал, хороодын хурал, ээлжит 27 дугаар хуралдаанд тус тус | 1-6 сард | 100.0 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцуулж ажиллалаа. Хөтөлбөрүүдийн дундаж үнэлгээг тодорхой үр дүнд хүрсэн буюу 82.2 хувийн үнэлгээтэй үнэлэгдсэн. Мөн аймгийн Засаг даргын 2024 оны эхний хагас жилийн А/01-А/517 дугаартай захирамжид хяналт-шинжилгээ хийж ажиллалаа. | | |
| 3. | Арга хэмжээ 4.3. Албан бичиг болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо | 2023 оны жилийн эцсийн байдлаар 4 албан бичиг ирсэн.<br><br>100.0 хувь | 20 албан бичиг<br><br>100.0 хувь | Жилийн эцсийн байдлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 20 шийдвэр, бусад байгууллагаас 6 албан бичиг ирснийг удирдлагад тунилцуулан цохолт хийлгэж, хариутай албан бичгийн хариуг цаг хугацаанд нь хүргэж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан. Иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол ирээгүй. | 1-12 сар | 100.0 хувь |
| 4. | Арга хэмжээ 4.4. Файлын эмх цэгцийг сайжруулах, хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу хэлтсийн баримтыг эмхлэн цэгцэлж, байгууллагын архивт хугацаанд нь хүлээлгэн өгөх | -Баримтын бүрдлийг хангаж, хугацаанд нь архивт шилжүүлсэн байдал<br>-Архивт шилжүүлсэн баримтын тоо | 2023 онд 6 хадагламжийн нэгж хүлээлгэн өгсөн. | 22 хадагламжийн нэгж | Файлын эмх цэгцийг сайжруулж, 2016-2024 он гэсэн полдэр үүсгэж, цэгцэлсэн. Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн байнга хадгалах 7 баримт, түр хадгалах 15 баримтыг ЗДТГ-ын архивт хугацаанд нь бүрэн шилжүүлсэн. | 3 сар | 100.0 хувь |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан байдал | | - | 6 | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагддаг “7:4:10” сургалтаар “Төрийн албаны шинэтгэл ба цэгцрэх хөдөлгөөн”, “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа” сэдвээр сургалт, мэдээлэл хүргэж, тус сургалтад хамрагдсан. Мөн төрийн албаны хөгжил, хамгааллын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт, НЭМҮТөвийн харьяа Иргэдийн хэрэглээний боловсролын төвөөс хүн амын эрүүл мэндийг хорт хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэр дундаа хүүхдийн эрүүл мэндийг хорт хавдраас урьдчилан сэргийлэх чиглэлээр болон эрүүл, зөв хооллолтын талаарх сургалтад, Эрүүл ажилтан байгууллагын үнэт капитал", сургалтад, 11 сард Удирдлагын академын “Залуу ментор” бэлтгэх сургалт, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан Орон нутаг дахь төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт, хэлэтцүүлэгт тус тус зэрэг сургалтуудад хамрагдсан. | 01-12 сар | 100.0 хувь |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг загварын дагуу 2024 оны 03 сард багтаан боловсруулж, батлуулах, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах | -Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаанд нь батлуулж, хугацаанд нь тайлагнасан байна. | - | 100.0 хувь | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралтын дагуу, журамд заасан хугацаанд төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан 19 арга хэмжээ төлөвлөж, хагас, бүтэн жилийн хэрэгжилтийг тайлагнан ажиллалаа. Жилийн эцсийн биелэлт 88.5 хувьтай байна. | 3-12 сар | 100.0 хувь |
| 2. | Арга хэмжээ 2. Англи хэл, Монгол бичгийн сургалтанд хамрагдах, бие даан судлах | -Англи хэл, Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлсэн байна. | Анхан шатны мэдлэгтэй | Сургалтад хамрагдаж түвшин ахисан байна. | Англи хэлийг цахим орчноос, болон ном, гарын авлагууд зэргээс бие даан судалж байна. Мөн англи хэлний Hippocards үг цээжилдэг апп-ыг утсандаа суулган өдөр тутамд өгөгдсөн даалгаварыг хийж, үгийг цээжлэн үгийн сангаа баяжуулж байна. Монгол бичгийг бие даан судалсан. | 10-11 сар | 70.0 хувь |
| 3. | Арга хэмжээ 3. Мэдээлэл технологийн хэрэглээний праграмм, салбарын хууль тогтоомж, дагалдаж гарсан дүрэм, журмыг бие даан судлах | -Хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.<br>-Хэрэглээний праграмм ашиглах | - | 100.0 хувь | Хууль тогтоомж, дүрэм, журмыг хуулийн нэгдсэн сайт, төрийн албаны зөвлөлийн цахим хуудас зэргээс татан авч нийт 40 журмаар эрх зүйн сан үүсгэсэн. | 3-12 сард | 100.0 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | чадвар дээшилсэн байна. | | | | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ҮНДЭСНИЙ БОЛОН ДЭД ХӨТӨЛБӨР, ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
*(Албан тушаал)*

............................................ / И.ОТГОНЦЭНД /
*(Нэр, гарын үсэг)*

2024.12.05
*(Огноо)*